

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Бугат сумын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021 /148/-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Цахим хаяг: [Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	<b>Error! Bookmark not defined.</b>
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	14
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	14
4. Менежментийн захидал .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 44

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Б.АРИУНТУНГАЛАГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторовн тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0060 0091

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>97,639,843.20</u></b>	<b><u>112,346,741.36</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,673,209.00	5,062,066.16
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,116,348.00	4,383,105.16
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	556,861.00	678,961.00
3351	Байгууллагаас авах авлага	506,861.00	628,961.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	50,000.00	50,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	94,966,634.20	107,284,675.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	94,966,634.20	107,284,675.20
35410	Бичиг хэргийн материал	-	99,000.00
35420	Аж ахуйн материал	90,842,655.20	104,165,105.20
35430	Сэлбэг хэрэгсэл	1,850,747.00	13,834.00
35440	Түлш, шатах тослох материал	1,076,000.00	-
35460	Хүнсний материал	172,332.00	41,836.00
35470	Бусад хангамжийн материал	1,024,900.00	2,964,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>551,781,657.15</u></b>	<b><u>2,651,116,144.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	551,781,657.15	2,651,116,144.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	506,065,407.21	2,604,049,894.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	465,755,662.09	2,563,287,437.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,789,412.44)	(52,387,942.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,500,000.00	9,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,500,000.00)	(1,959,999.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,131,521.64	91,264,231.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(131,509,202.59)	(56,405,024.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,878,291.66	39,955,815.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,320,331.14)	(22,658,673.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,010,006.60	31,933,866.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,676,886.03)	(12,805,030.07)
39217	Ном	13,585,757.42	14,025,213.92
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	45,716,249.94	47,066,249.94
39301	Програм хангамж	500,000.00	1,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(343,750.06)	(343,750.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,560,000.00	45,560,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>649,421,500.35</u></b>	<b><u>2,763,462,885.36</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,734,285.00</u></b>	<b><u>284,920.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,734,285.00	284,920.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,734,285.00	284,920.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	353,665.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,127,700.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	252,920.00	284,920.00
41361	Байгууллагад төлөх өглөг	252,920.00	284,920.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>646,687,215.35</u></b>	<b><u>2,763,177,965.35</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	646,687,215.35	2,763,177,965.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352,546,930.59	352,546,930.59
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(156,777,361.00)	1,959,713,389.00
51210	Өмнөх үеийн үр дүн	(156,777,361.00)	(156,777,361.00)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,116,490,750.00
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	450,917,645.76	450,917,645.76
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>649,421,500.35</u></b>	<b><u>2,763,462,885.35</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>507,225,231.40</b>	<b>2,786,581,383.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,706,131.40</b>	<b>2,131,274,083.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,109,700.00	2,131,274,083.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,109,700.00	2,131,274,083.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	337,700.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,772,000.00	2,131,274,083.50
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	9,596,431.40	-
122001	Хандив тусламж /дотоод/	9,596,431.40	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,519,100.00</b>	<b>655,307,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	437,273,100.00	515,511,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	437,273,100.00	515,511,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	800,000.00	76,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	76,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	57,446,000.00	139,719,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,446,000.00	139,719,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>560,238,503.13</b>	<b>669,468,217.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>560,238,503.13</b>	<b>669,468,217.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	550,004,655.28	626,959,734.76
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	328,747,510.00	381,279,449.00
210101	Үндсэн цалин	229,700,663.00	273,454,744.50
210102	Нэмэгдэл	55,489,447.00	72,201,770.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	43,557,400.00	35,622,934.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,326,977.00	48,208,831.76
210201	Тэтгэврийн даатгал	28,219,971.00	31,790,166.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,319,999.00	4,118,569.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,609,980.00	3,299,190.77
210204	Ажилгүйдлийн даатгал	652,521.00	906,296.74
210205	Эрүүл мэндийн даатгал	6,524,506.00	8,094,608.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	56,360,381.00	137,238,343.75
210301	Гэрэл, цахилгаан	5,300,381.00	5,427,445.75
210302	Түлш, халаалт	50,130,000.00	130,610,898.00
210303	Цэвэр, бохир ус	930,000.00	1,200,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,754,100.00	3,045,150.00
210401	Бичиг хэрэг	62,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,413,600.00	1,906,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	382,000.00	218,500.00
210404	Ном, хэвлэл	143,000.00	181,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,000.00	500,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	526,500.00	138,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,059,774.80	14,634,496.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	224,150.00	115,700.00
210502	Хоол, хүнс	22,735,224.80	14,264,596.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,400.00	254,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,708,850.00	1,142,000.00
210604	Урсгал засвар	2,708,850.00	1,142,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	121,000.00	614,500.00
210702	Дотоод албан томиллолт	121,000.00	614,500.00

**Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,895,139.00	3,698,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,823,139.00	3,374,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	324,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	78,030,923.48	37,098,564.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,070,853.60	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,785,188.00	2,501,384.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,174,881.88	34,597,180.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,233,847.85	42,508,482.33
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,600,253.85	7,141,713.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,865,253.85	6,311,713.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	735,000.00	830,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	6,225,256.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,225,256.25
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	633,594.00	29,141,513.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	633,594.00	29,141,513.08
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(53,013,271.73)</b>	<b>2,117,113,166.41</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	622,416.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	622,416.40
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(622,416.40)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(53,013,271.73)</b>	<b>2,116,490,750.01</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>495,897,400.00</b>	<b>655,307,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>337,700.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	337,700.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	337,700.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	337,700.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,559,700.00</b>	<b>655,307,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	437,313,700.00	515,511,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	437,273,100.00	515,511,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	40,600.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	800,000.00	76,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	76,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	57,446,000.00	139,719,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,446,000.00	139,719,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>495,534,400.00</b>	<b>653,377,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>495,534,400.00</b>	<b>653,377,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>484,535,966.00</b>	<b>612,697,330.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	330,863,858.00	379,516,766.00
210101	Үндсэн цалин	231,817,011.00	273,434,451.00

**Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210102	Нэмэгдэл	55,489,447.00	70,459,381.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	43,557,400.00	35,622,934.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,326,977.00	52,591,936.92
210201	Тэтгэврийн даатгал	28,219,971.00	36,173,271.63
210202	Тэтгэмжийн даатгал	3,319,999.00	4,118,569.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,609,980.00	3,299,190.77
210204	Ажилгүйдлийн даатгал	652,521.00	906,296.74
210205	Эрүүл мэндийн даатгал	6,524,506.00	8,094,608.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	56,618,881.00	138,853,743.75
210301	Гэрэл, цахилгаан	5,996,381.00	6,011,445.75
210302	Түлш, халаалт	49,692,500.00	131,642,298.00
210303	Цэвэр, бохир ус	930,000.00	1,200,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,329,100.00	7,009,934.00
210401	Бичиг хэрэг	172,000.00	199,384.00
210402	Тээвэр, шатахуун	2,551,600.00	1,747,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	313,000.00	281,500.00
210404	Ном, хэвлэл	143,000.00	181,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	214,500.00	1,816,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	935,000.00	2,783,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	20,361,600.00	17,310,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,500.00	139,500.00
210502	Хоол, хүнс	19,523,100.00	16,307,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	702,000.00	863,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	820,050.00	820,000.00
210604	Урсгал засвар	820,050.00	820,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	121,000.00	614,500.00
210702	Дотоод албан томилот	121,000.00	614,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,414,500.00	13,182,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,342,500.00	11,508,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	324,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,680,000.00	2,798,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,700,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,980,000.00	2,798,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,998,434.00</b>	<b>40,679,969.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,364,840.00	5,236,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,629,840.00	4,406,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	735,000.00	830,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	76,400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	76,400.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,225,256.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,225,256.25
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	633,594.00	29,141,513.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	633,594.00	29,141,513.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>363,000.00</u>	<u>1,930,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>363,000.00</u>	<u>1,930,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>363,000.00</u>	<u>1,930,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	363,000.00	1,930,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	1,900,000.00
223001	Бусад хөрөнгө	363,000.00	30,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(363,000.00)</u>	<u>(1,930,000.00)</u>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	(101,986,361.27)	701,478,215.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	(101,986,361.27)	701,478,215.08
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(54,785,271.73)	(54,785,271.73)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	(156,777,361.00)	646,687,215.35
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	(156,777,361.00)	646,687,215.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	(156,777,361.00)	646,687,215.35
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,116,490,750.00	2,116,490,750.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,546,930.59	450,917,645.76	1,959,713,389.00	2,763,177,965.35

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	667585100.00	619864130.67
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	667585100.00	619864130.67
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	656169200.00	614627330.67
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	395320900.00	379516766.00
210101	Үндсэн цалин	281619200.00	273434451.00
210102	Нэмэгдэл	72306500.00	70459381.00
210104	Урамшуулал	41395200.00	35622934.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53493200.00	52591936.92
210201	Тэтгэврийн даатгал	37539500.00	36173271.63
210202	Тэтгэмжийн даатгал	3988400.00	4118569.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	3190700.00	3299190.77
210204	Ажилгүйдлийн даатгал	797900.00	906296.74
210205	Эрүүл мэндийн даатгал	7976700.00	8094608.62
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	151253200.00	138853743.75
210301	Гэрэл, цахилгаан	12550000.00	6011445.75
210302	Түлш, халаалт	137503200.00	131642298.00
210303	Цэвэр, бохир ус	1200000.00	1200000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8948000.00	8939934.00
210401	Бичиг хэрэг	200100.00	199384.00
210402	Тээвэр, шатахуун	1750000.00	1747850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	313,600.00	311,500.00
210404	Ном, хэвлэл	181,700.00	181,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,816,400.00	1,816,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,686,200.00	4,683,800.00
2105	<b>Нормативт зардал</b>	29,727,400.00	17,310,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,900.00	139,500.00
210502	Хоол, хүнс	28,724,100.00	16,307,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	863,400.00	863,200.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	820,700.00	820,000.00
210604	Урсгал засвар	820,700.00	820,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	621,600.00	614,500.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	621,600.00	614,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,184,200.00	13,182,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,510,200.00	11,508,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	1,350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,800,000.00	2,798,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800,000.00	2,798,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,415,900.00	5,236,800.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,415,900.00	5,236,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,585,900.00	4,406,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	830,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	667,584,900.00	619,787,730.67
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	515,511,000.00	480,067,830.67
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	515,511,000.00	480,067,830.67
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	152,073,900.00	139,719,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	152,073,900.00	139,719,900.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Ариунтунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 22-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хэрэгжүүлэв.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага боловсрол
- Дунд боловсрол
- Бүрэн дунд боловсрол

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дотоод аудитын алба 2020 онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн 560244.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11204.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2114041.4 мянган төгрөгөөр буюу 325.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	556.9	679.0	122.1
Урьдчилгаа			
Бараа материал	94966.6	107284.7	12318.0
Үндсэн хөрөнгө	551781.7	2651116.1	2099.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>649421.5</b>	<b>2763462.9</b>	<b>2114041.4</b>
Өр төлбөр	2734.3	284.9	-2449.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	646687.2	2763177.9	2116490.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>649421.5</b>	<b>2763462.9</b>	<b>2114041.4</b>

Авлага дансны үлдэгдэл 679.0 мянган төгрөг болж 122.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 107284.7 мянган төгрөг болж 12318.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой үйл

ажиллагаа явуулаагүйгээс шалтгаалжээ. Бараа материалын үлдэгдлийн 97.1 хувийг аж ахуйн материал эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 551781.7 мянган төгрөг болж 2651116.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд сургуулийн шинэ барилга ашиглалтад орж санхүүгийн тайланд орлогоор бүртгэсэн байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 1900.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 2131274.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, акталсан 66075.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 1350.0 мянган төгрөгийн санхүүгийн программ бүртгэлд авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 284.9 мянган төгрөг болж 2449.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөр барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2763177.9 мянган төгрөг болж 2116490.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2279356.2 мянган төгрөгөөр буюу 449.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй орлого 2129502.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 682909.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 682909.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 15325.0 мянган төгрөгөөр бууруулж 667584.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 667584.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 515511.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 152073.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 515511.0, орон нутгийн төсвөөс 139719.9 нийт 655230.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 619864.1 мянган төгрөгийг зарцуулж 35443.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 619864.1 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 15804.1 мянган төгрөгөөр, байр ашиглалт 12399.5, норматив 12417.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 6000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 8000.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2.0	1	2.0	0	0	
Албан шаардлага	1	6.0	1	6.0	0	0	
Зөвлөмж	4	8	4	8	0	0	
Нийт дүн							

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5422.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 5422.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 5422.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Авлагын данстай холбоотой асуудал*

*1.1 Илрүүлэлт:* Тайлант онд НДШ 4383.1, хоол, хүнсний 45.7, материалын 633.3 нийт 5062.1 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

1.2 *Эрсдэл:* Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх,

1.3 *Өгсөн зөвлөмж:* НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж өр авлага үүсгэхгүй ажиллах.

*Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлын бүртгэлээр танилцуулсан. Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэн ажиллана.

2. *Зардлын данстай холбоотой асуудал*

2.1. *Илрүүлэлт:* Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 360.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2. *Эрсдэл:* Хууль журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах.

2.3. *Өгсөн зөвлөмж:* Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлын бүртгэлээр танилцуулсан. Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэн ажиллана.

3. *Шилэн данстай холбоотой асуудал*

3.1. *Илрүүлэлт:* Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 151 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.2. *Эрсдэл:* Хууль, журам зөрчигдөх, хэрэглэгч, харилцагч мэдээллээр хангагдахгүй байх.

3.3. *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

3.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ